

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНЫ 9 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2019 оны 09 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Нэг. Аймгийн ИТХ-ын ажлын алба:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн XIII хуралдаан хуралдаж 10 асуудал хэлэлцэж 6 тогтоол батлан хуралдааны тэмдэглэлээр 2 үүрэг өгөв. Үүнд:

1. “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явцыг хэлэлцээд уг төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлыг эрчимжүүлж, цаашид авах арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоож, хил залгаа аймгууд, бүс нутгийн хэмжээгээр нэгдсэн удирдлагаар зохион байгуулж байх асуудлыг судлан үзэх саналыг холбогдох дээд байгууллагад уламжлаж ажиллахыг аймгийн Засаг даргад даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

2. “Мах, сүүний анхдугаар аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явцыг хэлэлцээд “эрчимжүүлэх шаардлагатай 40%” гэж үнэлэгдсэн 6 арга хэмжээг хэрэгжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авах, аймгийн хэмжээнд хэрэглэгчдэд борлуулагдаж буй мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, ноос ноолуур, амьд малд эрүүл мэндийн үзлэг шинжилгээ хийж, гарал үүслийг тодорхойлсон гэрчилгээтэй болгох ажлыг эрчимжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалган хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

3. Мал аж ахуйн салбарын болон Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явцын тухай мэдээллийг хэлэлцээд Монгол улсын Засгийн газрын 2019 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 285, “Хот суурин газрын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай” 270 дугаар тогтоолууд, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас өгсөн үүрэг даалгавар, тогтоол, шийдвэрийг биелүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргаас гаргасан захирамжуудын заалт нэг бүрийг бүрэн хэрэгжүүлж, өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангах арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулсан ажлын үр дүнгийн талаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг даргад даалгаж, Тэмдэглэлээр өгсөн үүргийг өөрийн суманд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөн хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

4. Хөрөнгө шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцээд Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хавсралтад заасан дотуур байрны барилгыг актлаж, данснаас хасахыг зөвшөөрч тус тогтоолын 1-д заасан барилгыг актлаж, данснаас хасах, боломжтой материалыг ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгааллах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах, Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, актлагдсан барилгыг буулгаж газар чөлөөлөх ажлыг шуурхай зохион байгуулж, уг газарт сургуулийн шинэ барилга барьж зориулалтын дагуу ашиглуулах арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

5. 2015-2020 онд аймгаас баримтлах соёлын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэлэлцээд эрчимжүүлэх шаардлагатай, үнэлэх боломжгүй гэсэн гүйцэтгэлтэй байгаа зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад даалгав.

6. “Хөдөлмөрч манлай ахмад”-ыг шалгаруулах тухай асуудлыг хэлэлцээд “Олон улсын ахмадын өдөр”-ийг тохиолдуулан аймгийн “Хөдөлмөрч манлай ахмад” настан шалгаруулах журмын дагуу 11 ахмадыг шалгаруулав.

7. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017-2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцээд хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөв.

8. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 88 дугаар “Аймгийн 2020 оны төсвийн төслийн тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч Д.Батсуурийн хүсэлтийг хэлэлцээд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн “Аймгийн 2020 оны төсвийн төслийн тухай” 88 дугаар тогтоолын 2 дугаар заалтын 2.11 дэх хэсгийн “Алтанбулаг сумын ...100 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барих” гэснийг “Алтанбулаг сумын ...75 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барих” гэж өөрчлөн найруулан тус тогтоолыг батлав.

9. Төрийн дээд одон медальд уламжлах тухай асуудлыг хэлэлцээд Монгол Улсад Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн хүрээнд хөдөө аж ахуй, газар тариалангийн салбар, Төв аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд авъяас билэг, хүч хөдөлмөрөө дайчлан олон жил, үр бүтээлтэй ажиллаж үнэтэй хувь нэмэр оруулсан, мөн залуу хойч үеийг өөрийн арга туршлагаар залгамжлан хүмүүжүүлж байгаа нийт 72 иргэдийг Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

10.Төлөөлөгч томилох асуудлыг хэлэлцэв.

Аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ИТХ-ын Бодлогын хороодоос "Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын жил"-ийн ажлын явц, "Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих хөтөлбөр", "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явцтай танилцах, шалган туслах, сум, багийн Хуралд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид ажил эрчимжүүлэх, үр дүнд хүргэх зорилгоор 11 суманд ажиллаад байна.

Төвийн бүсийн аймгуудын ИТХ-ын Ажлын албаны ажилтнуудын туршлага солилцох уулзалт, зөвлөгөөн 9 дүгээр сарын 4-7-ны өдрүүдэд Дархан-уул аймагт 2 дахь удаагаа зохион байгуулагдсан бөгөөд үүнд холбогдох албан хаагчдыг хамрууллаа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг 9-р сарын 10-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлж, Зуунмод сумын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комисстой хамтран Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн хүмүүсийн аймгийн төвд ажиллаж, амьдарч байгаа үр хүүхдүүд, ач зээ нарт хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулан шашны ном хурууллаа.

ЗГХЭГ, Удирдлагын Академи, Монгол улсад төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх төсөлтэй хамтран 9-р сарын 25-27 ны өдрүүдэд зохион байгуулсан “Орон нутгийн түвшинд засаглалыг сайжруулж, хөгжлийг хангах ”нь сургалтад аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Доржсүрэн хамрагдав.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааныг 3 удаа хийж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлаас гадна 22 асуудал хэлэлцсэн.

Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудал хариуцсан хэлтэс, агентлагуулыг сум, орон нутагт ажиллахдаа төв суурин болон Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл, ургац хураалтын ажлын бэлтгэл, “Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт-2019” урианы жилийн ажлын явц, үр дүн шалгах чиглэл өгөв.

Сүмбэр сумын Засаг даргаар А.Баасанхүүг томилж, ажил хүлээлцсэн. Мөн тус сумын ЕБС-д шалган туслах ажлыг зохион байгуулсан.

27 сумын 97 багийн Засаг дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтад “Баг-97” төслийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудал сэдвээр мэдээлэл хийж, гаргасан санал

хүсэлтийг шийдвэрлэх төлөвлөгөө гарган, биелэлтийг тооцож хариу мэдэгдсэн. Мөн аймгийн 36 багийн Засаг даргыг Монголын нутгийн удирдлагын холбооноос зохион байгуулсан “Манлайлал, ур чадвар” сургалтад хамруулсан.

Ерөнхий сайдын үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3 дугаар улирлын биелэлтийг гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Төв суурин газраас алс нутаглаж байгаа малчин өрх, иргэдэд багаас үзүүлэх төрийн үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2019 онд 5 суманд багийн “Явуулын төвийн тоног төхөөрөмж”-ийн иж бүрдлийг орон нутгийн төсвийн 30.0 сая төгрөгөөр нийлүүлээд байна. Иж бүрдэлд асар майхан, зөөврийн дэлгэц, телевизор, цахилгаан үүсгүүр, чанга яригч, сургалтын ширээ, сандал, зургийн аппарат зэрэг тоног төхөөрөмж багтсан бөгөөд эдгээр нь хөдөөгийн багийн үйл ажиллагаанд чухал хэрэгцээтэй юм.

Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс багийн “Явуулын төв”-ийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөх ажлыг Лүн, Өндөрширээт сумдад зохион байгуулав. Тус ажлын хүрээнд Лүн сумын Цагаан-Уул /1 дүгээр/ багийн ИНХ-д оролцож, иргэдийн санал хүсэлтэд хариу өгөв. Мөн Өндөрширээт суманд зохион байгуулсан баялаг бүтээгчдийн “Алтан намар” үзэсгэлэн худалдаанд оролцсон юм. Төв аймгийн хэмжээнд 12 сумыг багийн Явуулын төвийн тоног төхөөрөмжөөр хангаад байна.

Монгол Улсад Атар газар эзэмшсэний 60 жилийн ой, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд тариаланч ногоочдоо дэмжих, ургац хураалтын ажилд нь туслах зорилгоор аймгийн ЗДТГ-ын даргын 2019 оны А/53 дугаар тушаалаар “Намрын ажил-2019” арга хэмжээг зохион байгуулахад ЗДТГ-ын 80 гаруй албан хаагчид оролцож, 10 тонн хүнсний ногооны худалдан авалт хийлээ.

Мөн албан хаагчдын эрүүл мэндийн цогц үзлэг, шинжилгээг 2019 оны 09 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Улаанбаатар хотын “Эмчийн өргөө” эмнэлэгтэй зохион байгууллаа. Үзлэгээр нарийн мэргэжлийн эмч нар биохими, цусны шинжилгээ авч, зүрхний бичлэг, бамбай булчирхай, хөхний ЭХО, биоскан төхөөрөмжийг ашиглан 32 эрхтнийг 240 үзүүлэлтээр нарийвчилсан үзлэг хийсэн.

2019 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс аймгийн Засаг даргад хандаж ирүүлсэн 74 иргэний тодорхойлолтыг Засаг даргын Зөвлөлийн 2019.09.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, /Үүнээс ТАХ 7/ холбогдох яам, дээд шатны байгууллагад уламжлаад байна. Холбогдох яам, дээд шатны байгууллагаас дэмжигдэж ирсэн 74 иргэний материалыг /Үүнээс ТАХ 7/ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.09.12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 82 иргэн, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 124 иргэнийг шагнаж, урамшууллаа.

Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын удирдах ажилтны нэгдсэн шуурхайг 2 удаа зохион байгуулж 27 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

МУЗГ-ын 1111 төвд өссөн дүнгээр 37 санал хүсэлт, гомдол, талархал ирснээс 32 санал хүсэлт, гомдол, талархлыг шийдвэрлэсэн бөгөөд, 5 нь шийдвэрлэх шатандаа байна.

Төрийн албаны стандартын хүрээнд: Аймгийн хэмжээнд сумдын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын дунд сургууль, Цэцэрлэгийн удирдах ажилтны сул орон тооны захиалгыг албан тушаалын тодорхойлолтын төслийн хамт Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв. .

ТАЗСЗ-өөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2019.09.30-ны байдлаар тоогоор/

	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	20
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	2
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	1
5	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар	-
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	-
НИЙТ ДҮН		23

2019 оны 09 дугаар сарын 30-ны байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй
1	Албан бичиг	190	28	27	1
2	Өргөдөл, гомдол	31	31	30	1

Гадаад харилцаа: Гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд шууд харилцаат Япон улсын Изүмисано хотын Никко зочид буудалд дадлагажих 2 дадлагажигчтай аймгийн удирдлагууд уулзаж, үүрэг чиглэл өгөв. Энэ 2 дадлагажигч амжилттай сурч, мэргэшсэнээр дараагийн ээлжийн залуусд өргөн боломж олгох юм.

Япон улсын Тоттори мужийн ХААИС дээр 10-р сараас 12-р сард болох далд хөрсний технологийн сургалт-дадлагад Сүмбэр сумын ЗДТГ-ын бэлчээр, тэжээл, газар тариалан хариуцсан мэргэжилтэн Б.Цогзолмаа хамрагдах болж, бэлтгэлийг бүрэн хангав.

БНСУ-ын Сөүл хотын Их сургуулийн захирал Со Сүн Так тэргүүтэй төлөөлөгчид 2019 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр аймгийн ЗДТГ-т ажиллаж, Сөүлийн Их сургуулийн хилийн чанад дахь салбар сургуулийг Төв аймгийн Зуунмод хотод байгуулахаар болж, хамтын ажиллагааны “Санамж бичиг”-ийг байгуулав. “Сөүлийн Их сургуулийн хилийн чанад дахь хотхон” төслийн үйл ажиллагаа 2019 оноос эхэлж, үе шаттай хэрэгжсэнээр 2023 оны 9 дүгээр сараас анхны оюутнуудаа хүлээн авахаар төлөвлөсөн.

БНХАУ-ын Ляонин мужийн намын байнгын хорооны гишүүн, сурталчилгааны яамны сайд Zhang Funai тэргүүтэй төлөөлөгчид 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр аймгийн ЗДТГ-т зочилж, хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр уулзалт зохион байгуулав. 2009 онд байгуулсан Санамж бичгийн хүрээнд хамтын ажиллагаагаа олон салбарт өргөжүүлж, эрчимжүүлэхээр тохиров.

Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнийн урилгаар Монгол улсад айлчилсан Бутаны Вант улсын Дотоод хэрэг, соёлын сайд Дашо Шеруб Гелтшэн /Sherub Gyeltshen/ тэргүүтэй төлөөлөгчид, ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэн, ОНУЗГ-ын дарга Т.Зоригтбаатар нар Төв аймагт ажилласан. Энэ үеэр орон нутгийн засаглалыг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд хийгдсэн ажлын туршлага, гарсан ололт, амжилтыг судлахаар ирсэн гэдгээ илэрхийлж, Төрийн үйлчилгээний Нэгдсэн төвийн үйл ажиллагаатай танилцлаа.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2019 оны 09 дүгээр сарын байдлаар Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт 23 байгууллага 300 гаруй төрлийн үйлчилгээг 7000 гаруй иргэнд, өдөрт дунджаар 300-350 иргэнд шуурхай хүргэн ажиллаа.

Аймгийн веб сайтад 41, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд 97 мэдээ мэдээлэл нийтлэгдсэн. 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн 4-н дугаар, мөн бусад телевизүүдийн мэдээний цагаар давхардсан тоогоор 84 мэдээ мэдээллийг бэлтгэн давхардсан тоогоор 186 удаа иргэд, олон нийтэд хүргэлээ.

7027-1111 нээлттэй утсанд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой 11 гомдол санал ирснийг холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлэв.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: Тус газар нь 2019 онд 521 төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс гуравдугаар улирлын байдлаар 426 буюу 81,7%-ийг, 238 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээс 188 байгууллага буюу 86,1% хамруулан зөвлөн туслах үйлчилгээг хийж гүйцэтгэсэн байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалт: Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/132 тоот удирдамжийн дагуу Боловсрол, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр Жаргалант сумын ЕБС, Зуунмод сумын Сент Поул сургуулиудад гүйцэтгэлийн хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. Зөрчил гаргасан хуулийн этгээдийг Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтын дагуу 500.0 мянган төгрөгөөр захиргааны арга хэмжээ авч, материалыг прокурорт хянуулж байна. Хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд 1 цэцэрлэгээс ундны усны дээж авсан.

Баянчандмань, Борнуур суманд эрүүл мэндийн чиглэлээр сувиллын үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 19/133, 19/134 тоот удирдамжаар төлөвлөгөөт шалгалт болон зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж эрсдэлийг тооцон зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардлагыг хүргүүлсэн.

Төлөвлөгөөт бус шалгалт: Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/147 дугаартай удирдамжийн дагуу Баянчандмань сумын нутагт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Монвольфрам ХХК-ийн үйл ажиллагаанд Геологи, уул уурхай, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар гадаад ажилтны квот, ажлын байрны төлбөр, зэргийг үзэж шалгав.

Бусад хяналт: Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын 01/235 тоот удирдамж, “Хүүхдийн эрх, аюулгүй байдал” сарын аяны хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 19/140 тоот удирдамжаар худалдаа үйлчилгээний байгууллагын ажиллагсад болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдүүдэд хийгдэж байгаа үзлэг, шинжилгээний чанар аюулгүй байдлыг нэгдсэн эмнэлгийн нян судлалын лаборатори, рентгений болон арьсны кабинетүүдэд төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, танилцуулга материалыг МХЕГ-т албан бичгээр хүргүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 4 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлагыг /19-03-032/288/ АНЭ-т хүргүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Андууд худалдааны төвд зарагдаж буй хүнсний ногоо, жимс, жимсгэнэд агуулагдах цацраг идэвхт изотопын хэмжээнд тандалт судалгаа хийж, тандалт судалгааны танилцуулгыг МХЕГ-т хүргүүлсэн.

Геологи, уул уурхайн хяналтаар: Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 19/48 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу Сэргэлэн сумын нутагт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гурвалсан гэрээ байгуулсан 1 нөхөрлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдалд Зөрчлийн тухай хуулийн дагуу 1500 нэгжтэй тэнцэх шийтгэлийн арга хэмжээ авч, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлд заасан эрх бүхий албан тушаалтны даалгаврыг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Төв аймгийн прокурорын газраас хэрэг бүртгэлийн 183400591, 183400323 дугаартай хэргийг хааж харьяаллын дагуу шилжиж ирсэн Заамар сумын нутагт зохих зөвшөөрөлгүй, бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 150 нэгжийн шийтгэл, 2,725,258 төгрөгийн нөхөн төлбөрийг оногдуулж прокурорын хяналтад хүргүүлсэн.

Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр шүдний протезийн үйлдвэрлэл эрхэлж байгаа Ган дөш, Уран дент эмнэлгүүдэд тандалт судалгаа хийж, танилцуулгыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Баянчандмань сумын хоол үйлдвэрлэлийн 12 газарт иргэний гомдлын дагуу эрүүл ахуй халдвар хамгаалал, хүнсний чанар стандартын чиглэлээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж байна.

Мал эмнэлэг: Төв аймгийн Зуунмод суманд 2019 оны 09 дүгээр сарын 11-13-ны хооронд зохион байгуулагдсан “Гойд ашиг шимт мал, цагаан идээний үзэсгэлэн,

худалдаа” арга хэмжээнд 21 аймгийн төлөөлөл оролцож, шилмэл мал, цагаан идээг шалгаруулсан. Үзэсгэлэнд ирсэн малыг угааж ариутгах, цагаан идээний чанар аюулгүй байдалд хяналт тавьж ажилласан.

Итгэмжлэгдсэн лаборатори нь хүнсний ногооны 99 сорьцыг шалгаж хүлээн авч 541 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгосон байна.

Онцгой байдлын газрын хүрээнд: Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/263 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу ОБЕГ-ын Дотоод хяналт, шалгалт, аюулгүй байдлын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, аюулгүй байдлын хэлтсийн дарга хурандаа Б.Батболдоор ахлуулан ажлын хэсэг Төв аймгийн Онцгой байдлын газарт 2018 онд зохион байгуулагдсан иж бүрэн шалгалтын биелэлтийн шалгасан.

ОБЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу Хар тамхи, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэргийн тухай ойлголт, түүний хор уршиг, хэрхэн урьдчилан сэргийлэх тухай онлайн сургалтыг нийт бие бүрэлдэхүүнд зохион явууллаа.

Архангай аймагт зохион байгуулагдсан хойд бүсийн Онцгой байдлын газрын Холбоо зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, Шуурхай удирдлагын оператор, аврагч-жолооч холбоочдын сургалтад Онцгой байдлын газрын томилгоот бүрэлдэхүүн хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Онцгой байдлын газрын Ёс зүйн алба 9 дүгээр сард 1 удаа хуралдаж сахилга ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчийн асуудлыг хэлэлцэж, газрын ёс зүйн албаны санал дүгнэлтийг газрын даргад уламжиллаа. Газрын дотоод хяналт шалгалтын зөвлөл төлөвлөгөөний дагуу авто машин, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдалд үзлэг шалгалтыг зохион явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах үүрэг даалгаварыг хариуцсан алба хаагч нарт өгч хэрэгжилтэд хяналт тавьж байна.

Онцгой байдлын газрын даргын 4 удирдамж батлуулан, Эрдэнэ, Баянцогт, Лүн, Мөнгөнморьт сумдад “БЭЛЭН БАЙ” багцаар сургалт зохион байгуулсан.

Аймгийн ерөнхий боловсролын 20 сургуулийн ахлах ангийн сурагчдад аюулгүй амьдрах арга ухааны мэдлэг эзэмшүүлэх, аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх, аврах, өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэхэд сургаж дадлагажуулах зорилгоор аймгийн хэмжээнд “Өсвөрийн аврагч-2019” тэмцээнийг 2019 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр зохион байгуулав. Тэмцээнд нийт ерөнхий боловсролын 9 сургуулийн 72 баг тамирчид өрсөлдсөнөөс гуравдугаар байранд Жаргалант сумын ЕБС-ийн баг тамирчид, хоёрдугаар байранд 4 дүгээр сургуулийн баг тамирчид, нэгдүгээр байранд Хүмүүн цогцолбор сургуулийн багууд тус тус шалгарлаа.

Хойд бүсийн өсвөрийн аврагч тэмцээн 2019 оны 09 дүгээр сарын 28-нд Дархануул аймагт зохион байгуулагдаж, 7 аймгийн 50 гаруй тамирчид оролцож, багийн дүнгээр 5 дугаар байр эзэлсэн.

Онцгой байдлын газрын даргын баталсан “Бэлтгэл бэлэн байдал”-ыг хангуулах тухай тушаалын дагуу удирдамж боловсруулж “Цуглар” дохиогоор 2 удаа цуглуулж бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг шалгалаа. Мөн хуурайшилт эхэлсэнтэй холбогдуулан сумдын Засаг дарга нарт “Ой хээрийн түймэр”-ээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээг хүргүүлэв.

Сэргэлэн, Эрдэнэ, Баян сумдад удаа дараа баавгай айлын хот руу ирээд байна гэсэн дуудлагын дагуу ОБГ-ын дарга, МХГ-ын дарга, ЦГ-ын дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дээрх сумдад үүрэг гүйцэтгэсэн. Үүний дагуу сумдын Засаг дарга нарт баавгайн дайралт болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, заавар зөвлөмжийг хүргүүлэв.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2017-2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд 83.22%-тай дүгнэгдсэн.

МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан “Хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалцаа” уриатай Авто спортын мастер Д.Батзоригийн 11 аймгийн нутаг дэвсгэрээр 5000 гаруй км-ийг дайран өнгөрөх адал явдалт авто аялалын багийг хүлээн авч, ГБХЗХГ, НБХ, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газартай хамтран холбогдох үйл ажиллагааг зохион байгуулж, аймгийн удирдлагуудыг “Яараад яахав дээ” аянд нэгтгэж ажиллалаа. Түүнчлэн “Хайртай” аян болон “Атрын шан-2019” залуучуудын олон нийтийн үйл ажиллагааны үеэр “Яараад яахав дээ” аяныг олон нийтэд сурталчиллаа.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн 09 дүгээр сарын ээлжит хурлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны мэдээллийг хэлэлцүүлж, шаардлагатай техник хэрэгсэл болон үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр харьяа дээд газарт хүсэлт уламжилж, зохих арга хэмжээг авч ажиллахаар шийдэрлэлээ.

Архивын үйлчилгээ: Тайлант хугацаанд архивын эх баримтаас 115 иргэний хүсэлтээр 220 хуулбар хувь, 67 лавлагаа гарган үйлчилсэн бөгөөд 589.2 мян.төг-ийн орлого төсөвт төвлөрүүлэв. 2 хөмрөгийн 77 хадгаламжийн нэгжийн 4958 хуудас баримтын 16424 хүний нэр, заалт, 4096 тушаалын тоон мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 4958 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэж, 2 хөмрөгийн 233 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийлээ.

Улсын бүртгэлийн үйлчилгээ:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр: Тайлант хугацаанд цахим санд нийт 51779 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 9591, Газар өмчлөх эрхийн 42188 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 22846 байв. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 139 үл хөдлөх худалдан борлуулсны орлогоос 109.0 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 2.9 сая төгрөгийг тус тус улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр: Тайлангийн хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд нийт 176 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 135 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 40, хууль хяналтын байгууллагад 38 лавлагаа мэдээллээр үйлчиллээ. Орон нутгийн төсөвт 9.7 сая төгрөгийг орууллаа.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл: Аймгийн нутаг дэвсгэрт энэ сард 587 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4.9%-иар өссөн. Зөрчил 1575 бүртгэгдэж 216 нэгжээр буюу 13.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 39.2 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 6.3 хувиар өсчээ.

“Хичээлийн шинэ жил 2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд сургууль бүр гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон болох ажлыг эрчимжүүлэх зорилгоор Эрүүгийн хуулийн тухай онцлог, хариуцлага хүлээлгэх насны хязгаар сэдвээр 165 бүлгийн 10425 сурагчдад, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 770 суралцагч нарт сургалт хийсэн.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа: Энэ сард эрүүлжүүлэгдсэн-27, баривчлагдсан-28, саатуулагдсан-8, нийт 63 хүнийг хүлээн авч ар гэр асран хамгаалагчид 13 хүнийг хүлээлгэн өгч ажиллав.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Олон нийтийг хамарсан 53 удаагийн арга хэмжээнд хамгаалалтад 557 алба хаагч, 346 тээврийн хэрэгсэл, 1424 тусгай хэрэгсэл, 434 станцтай 2227 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж 13840 орчим иргэний аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 47 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 11 иргэнийг сум дундын сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5088 жолоочийг 157.806.0 төгрөгөөр торголоо.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Энэ сард Криминалистикийн шинжилгээ-131, Нийт хийсэн магадлан шинжилгээ-152, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-439, гарын мөрийн санг баяжуулсан-112, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 707 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
09 дүгээр сар	398	424	72	750	358	392	47.7
	3920610.2	4151516.4	1662010.8	6410116	1800386.2	4609729.6	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

ХАА-н чиглэлээр: Аймгийн ургац хураалтын зөвөлгөөнийг Жаргалант суманд зохион байгуулахад тариалан бүхий сумын 86 тариаланч ногоочид оролцож, төрөөс газар тариалангийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, 2019 оны тариалалт ургалтын байдал, ургац хураах технологи, цаашид анхаарах асуудлуудын талаар санал солилцсон.

Ургац хураалтын бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор аймгийн ургацын штабыг 2 удаа хуралдуулж, цаг үеийн асуудлуудыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Ургац хураалтын ажилд боловсон хүчний дэмжлэг үзүүлэх асуудлыг холбогдох байгууллагад хүргүүлж ажилласнаар 600 гаруй цэргийн албан хаагч, Зуунмод, Заамар, Баянчандмань, Эрдэнэ суман дахь МСҮТ-ийн 273 сурагч ажиллаж байна.

2019 онд тарьсан нутагшсан болон ирээдүйтэй сортын биологийн хянан баталгааг 6 сумын 26 аж ахуйн нэгж, иргэний 3629.8 га талбайд хийсэн. Сортын хянан баталгаанд Алтайская-75 сорт 1162 га, Алтайская -325 сорт 855 га, Дархан-144 сорт 706.8 га, Дархан-181 сорт 100 га, Дархан 34 сорт 90 га, Буриадская остистая 412 га, Тоболская сортын 304 га талбай тус тус хамрагдсан.

Монгол Улсад атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсэний 60 жилийн ойд зориулж ХХААХҮЯ, Монголын үндэсний телевизийн хамтран зохион байгуулсан тариалангийн салбараас төрөн гарсан баатаруудыг оролцуулсан “Баатаруудаараа бахархaya” теле уулзалт, нэвтрүүлэгт Жаргалант сумын 5 хөдөлмөрийн баатарыг оролцууллаа.

Үр тариа 941 га талбайгаас 915 тн ургац хураан авч 1,2%-тай, Төмс 4.7 мянган га талбайгаас 51.5 мянган тн ургац хураан авч 60%-тай, хүнсний ногоо 405 га талбайгаас 5.6 мянган тн ургац хураан авч 34.8%-тай, Малын гэжээл 3.5 мянган га талбайгаас 8.5 мянган тн ургац хураан авч 33%-тай ургац хураалтын ажил явагдаж байна. Ангилаан хадалт 8.1 мянган га талбайд хийсэн

Мал аж ахуй: “Шилмэл мал-2019” нэгдсэн арга хэмжээг Төв аймагт зохион байгуулахад 17 аймгийн 540 гаруй мал, амьтад оролцож, гойд ашиг шимт малын дуудлага худалдаагаар 42,5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.

Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор 27 сумтай цахим хурал хийж, аюулгүйн нөөцөө бүрдүүлэх, малчин, мал бүхий иргэдийн хувийн бэлтгэлийг

эртнээс хангуулах, худаг уст цэгийн засвар, дулаалга, хашаа, хорооны бэлэн байдал, мал сүргийн ангилалт, заазлалт явуулах талаар үүрэг, чиглэл өгөөд байна.

Аймгийн хэмжээнд урьдчилсан тооцоогоор 2019-2020 оны өвөл, хаварт 4,9 сая толгой мал буюу хонин толгойд шилжүүлсэнээр 8,6 са толгой мал өвөлжинө. Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны отрын бүс нутагт 8 сумын 202 өрхийн 188.7 мянга, Хөх дэл, Чилэнгийн бүс нутагт 4 сумын 89 өрхийн 66,2 мянга, өөр аймгийн нутагт 15 сумын 146 өрхийн 100,4 мянган толгой мал өвөлжиж, хаваржих саналаа ХХААХҮЯ-нд хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар малчин, мал бүхий иргэд 121,8 мянган тн хадлан, 35,5 тн гар тэжээл бэлтгэх даалгавар өгөгдсөнөөс 41575,0 тн хадлан, 1530 тн гар тэжээл, 1236 тн ногоон тэжээл тус тус бэлтгээд байна. Хадланд том оврын трактор 342, бага оврын трактор 742, автомашин 503, гар хадуур 419, чиргүүл 224, хаман боогч 137, 3033 хүн, 157 хадлангийн салаа ажиллаж байна.

2019 онд Засгийн газрын тогтоолоор аймгийн хэмжээнд аюулгүйн нөөцөд 3080 тн өвс, 1450 тн тэжээл нөөцлөх төлөвлөгөөтэйгээс аймгийн аюулгүйн нөөцөд 380 тн өвс, 150 тн тэжээл, сумдад 314,5 тн өвсний үлдэгдэлтэй байна.

Аймгийн Засаг даргын санаачилгаар гар тэжээл бэлтгэх ажлыг бүх нийтийн аян болгон өрнүүлж, зөвлөмж гарган бүх сум, албан байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлсэнээр одоогийн байдлаар 12 тн гар тэжээл бэлтгэв.

Тайлант хугацаанд 29 худаг шинээр гаргаж, 25 худгийг суманд хүлээлгэн өглөө.

Үйлдвэрлэл, үйлчилгээ: “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын дагуу аймгийн Засаг даргын 2019.08.12-ны өдрийн А/456 тоот захирамжаар баталгаажуулсан 1.0 тэрбум төгрөгийн 17 төслийг Хаан, Төрийн банкаар судлагдаж байгаас 5 төслийн 370.0 сая төгрөгийн зээлийн санхүүжилт олгогдож, 12 төсөл судлагдах шатанд явагдаж байна.

ХХААХҮЯ-тай хамтран зохион байгуулсан “Шилмэл мал-2019” гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдааны үеэр Төв аймгийн 14 сумын 36 иргэний 30 гаруй нэр төрлийн сүү, цагаан идээний бүтээгдэхүүнээр оролцож 15.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулав.

“Намрын ногоон өдрүүд-2019” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үзэсгэлэн худалдаанд хүнсний үйлдвэрлэл эрхлэгч 4, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалан эрхлэгч 7, нийт 11 аж ахуйн нэгж, иргэн, хоршоо оролцож, 15.8 сая төгрөгийн борлуулалт хийж, өмнөх жилтэй харьцуулахад борлуулалт 2 дахин нэмэгдлээ.

2019-2020 онд өвөлжих болон хүнсэнд хэрэглэх, зах зээлд нийлүүлэх малын урьдчилсан судалгаагаар нийт мал сүргийн 31 орчим хувь буюу 1.4 сая.толгой малыг хүнсэнд болон зах зээлд нийлүүлэхээр төлөвлөсөн. Мал, мах бэлтгэлийн мэдээгээр “Эрдэнэ хүнс” махны үйлдвэр мах 650 тн, “Баяндэлгэр хүнс” махны үйлдвэр 70.0 тн, Зуунмод мах боловсруулах үйлдвэр 10.7 тн мах, Аргалант сумын “Экофүүдс” ХХК-ын махны үйлдвэр-470 тн, Алтанбулаг, Лүн, Эрдэнэсант, Сэргэлэн сумдын мал төхөөрөх цехүүд 638 тн, нийт 1028 тн мах үйлдвэрийн аргаар бэлтгэсэн зах зээлд нийлүүлээд байна.

Мал эмнэлгийн үйлчилгээ: Шүлхийн халдварын тандалтад сонгогдсон 4 сумын 2 багийн 15 малчин өрхөөс 900 ийлдсийн дээжийг шүлхийд мэдрэмтгий үхэр, хонь, ямаанаас мөн БММӨ тандалтад 4 сумын 3 багийн нийт 10 малчин өрхөөс 400 ийлдсийн дээжийг хонь, ямаанаас цус авч бэлдсэн.Шүлхий өвчний ELISA урвалын дүнгээр Дэлгэрхаан сумын 2 үхэр, Бүрэн сумын 1 хонь, Өндөрширээт сумын 2 үхэр, 2 ямаа эерэг урвал үзүүлэв.

Хээлтүүлэгчийг бруцеллез өвчнөөс сэргийлэх тандах шинжилгээг хийх зорилгоор 27 сумын 24102 мян бух, буур, хуц ухныг бүрэн хамруулан дээж авч, шинжилгээний ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

Лүн сумын МЭХЦХЦ-ийн хяналтын цэг 707 тээврийн хэрэгсэл, адуу 2445, үхэр 2208, хонь 25120, ямаа 8395 толгой, тэмээ 2178 толгой, цаа буга 3, мах, махан

бүтээгдэхүүн 33060 кг, арьс шир 400 ширхэг, ноос 112.5 тн, өлөн 250 ширхэг, айраг 5 тн, цагаан идээ 700 кг, өвс 700 ширхэг, зэрэг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд МЭАЦ-ийн гарал үүслийн гэрчилгээ олгосон байдлыг үзэж шалган, 4242 м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийлээ. Зөрчилтэй тээврийн хэрэгсэл 115 явсныг хянан шалгаж тухай бүр нь арга хэмжээ авч ажиллав.

Хөрөнгө оруулалт, барилга хот байгуулалтын үйлчилгээ: 2019 онд аймгийн хэмжээнд улс, орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар 85,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна.

- ✓ 770 хүүхдийн 7 дотуур байр
- ✓ 6 соёл, спортын төвийн барилга
- ✓ 550 хүүхдийн 5 цэцэрлэг
- ✓ 2200 хүүхдийн 4 сургууль
- ✓ 10 ортой 1 ЭМТ-ийн барилга
- ✓ 12 оффис, контор, багийн төвийн барилга

Нийт 35 барилга шинээр баригдаж, 12 барилга их засварт хамрагдаж байна. Мөн:

- ✓ 39 худаг шинээр гаргаж
- ✓ 6 чиглэлийн 77 км автозам баригдаж эхэллээ.

Аймгийн хэмжээний нийт хөрөнгө оруулалт, их засварын ажлууд 77,6%-тай хэрэгжиж байна.

- УХО-ын 2018-2019 онд шилжих 18 төсөл, арга хэмжээний 12 төсөл арга хэмжээ бүрэн дууссан. 5 барилга 80-95 хувийн гүйцэтгэлтэй, нийт ажлын явц-96,9% байна.
- УХО-ын 2019 онд эхэлсэн 23 ажлуудаас 5 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих бөгөөд ажлын явц- 44,0%, Нийт төсөл арга хэмжээ 69,0% байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтад 4268.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 43 төсөл, арга хэмжээ 74,6%-ийн гүйцэтгэлтэй.
- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 13 төсөл, арга хэмжээнээс зам барилга, засварын ажлууд бүрэн дууссан ба засвар арчлалтын ажлын хугацаа болоогүй байна. Нийт арга хэмжээ 90,5%-ийн гүйцэтгэлтэй.
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 13 төсөл, арга хэмжээ- 91,7%-ийн гүйцэтгэлтэй.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтад 1958.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Нийт 41601.4 сая төгрөгийн 65 төсөл арга хэмжээнд тендер зарлахаас 61 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж хэрэгжилт 94,0%-тай байна.

Тайлант сард 7 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталж, 11 барилгын эх загвар болон ажлын зураг төслийг хянаж зөвшөөрөл олгосон. Мөн 4 барилга байгууламжийн эхлүүлэх зөвшөөрөл олгов.

Барилга, хот байгуулалтын салбарын хэмжээнд дараах онцлог ажлууд хийгдэж байна. Үүнд:

- Монгол Улсын анхны 32,2 км хурдны автозам ашиглалтад орлоо.
- Аймгийн нутаг дэвсгэрт Олон улсын шинэ нисэх онгоцны буудал баригдаж ашиглалтад орлоо.
- Аймгийн төв Зуунмод хотод 450 айлын орон сууцны барилгын ажил эхэлж, 2000 айлын орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулж хороолол барих нөхцлийг хангаад байна.

Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд: Аймгийн хэмжээнд 2019-2020 оны халаалтын улиралд 23 сум, 1 баг /Заамар сумын Хайлааст баг/ төвлөрсөн халаалтын системтэйгээр бусад сумд хэсэгчилсэн халаалтын системтэйгээр ажиллана. Одоогоор 23 сум төвлөрсөн халаалтын системд холбогдоод байна.

Улс, аймгийн хөрөнгө оруулалтаар 1360.0 сая төгрөгийн дулаан, цэвэр, бохир ус, цахилгаан хангамжийн шугам сүлжээний ажлууд хийгдэж байна.

Аймгийн дүнгээр халаалтын хугацаанд нийт 86,3 мянган тн нүүрс, үүнээс Зуунмод суманд 52,0 мянган тонн нүүрс шаардлагатай байгаагаас 30 хувийг нөөцлөх гэрээ хэлцэл хийгдэж байна. Нүүрс нөөцлөхөд зориулж 419,0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгов.

Манай аймгийн сумдыг эрчим хүчээр ханган ажилладаг Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ, УБЦТС-ний Налайх түгээх төв, Зуунмод түгээх төв, Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээний Хархорин дахь салбар, Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээний газартай хамтран ажиллаж байгаа бөгөөд нийт 601,6 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн байна.

Аймгийн төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө 84,7 хувийн хэрэгжилттэй байна.

Газрын харилцааны үйлчилгээ: Улсын тусгай хэрэгцээнд авсан 12000 га газарт “Майдар ус” ХХК-ний Усны үйлдвэр, “Баатрууд тэнгэр” ХХК-ний Хүлэмжийн аж ахуй, “Рамон” ХХК тариалангийн талбайд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжийн эзэмшил газрыг Майдар төслийн ерөнхий төлөвлөгөөнд тусгуулах санал хүргүүлсэн.

Өндөрширээт, Батсүмбэр, Аргалант, Баянцогт, Дэлгэрхаан сумын газрын даамлуудтай хамтран Баянчандмань, Батсүмбэр сумын “Лэнд менежер” программ хангамжийн нөхөн бүрдүүлэлтийг хийн 800 нэгж талбарыг бүртгэж, 51 нэгж талбарын зөрчил арилгасан.

2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Алтанбулаг сумын 1-р багийн Иргэдийн Нийтийн Хуралд оролцож, Газрын тухай хууль, газрын олголтын байдал, нутаг дэвсгэрийн нэрийн зураг, тухайн жилийн газар зохион байгуулалтын талаар мэдээлэл өглөө.

ГЗБГЗЗГ-т 27 сумын газрын төлбөрийн итгэлцүүрийг зориулалт бүрээр шалгасан. ЛМ-ийн web хувилбарт Зуунмод сумын 1085 хүчинтэй гэрээ бүртгэгдсэнээс 500 гэрээнд газрын төлбөрийн ногдуулалтыг нэг бүрчлэн хийсэн. Газрын төлбөрийн орлого 1170,7 сая төгрөг төвлөрүүлэхээс 2123.5 сая төгрөг төвлөрч 181.3%-ийн биелэлттэй байна.

Байгаль орчны чиглэлээр: Төв аймгийн Зүүн бүс нутгийн Түүх, археологийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, шинэ маршрутыг аймгийн аялал жуулчлалын зураглал дээр орууллаа.

Монгол Улсад ойн салбар үүсэн байгуулагдсаны 95 жилийн арга хэмжээг БОАЖЯ, МУИС- тай хамтран Батсүмбэр сумын Үдлэг багт зохион байгуулж, ойн ангиуд болон ойн мэргэжлийн байгууллагуудын “Ур чадварын тэмцээн”-д багаараа 3 байр эзэлсэн.

Зуунмод сумын цэцэрлэгт хүрээлэн бүхий ногоон байгууламжийн арчилгаа, хамгаалалтыг ойн мэргэжлийн байгууллага болох “Тахилт төгөл” ХХК-д хариуцуулан, ногоон байгууламжийн тооллого зохион байгууллаа. Тооллогын дүнгээр 7 төрлийн 4900 ширхэг мод тарьсанаас 56,4 буюу 2765 ширхэг мод амьдрах чадваргүй болсон. 7 төрлийн ургаж байгаа модноос Шар хуайс 140 ширхэг, Агч 40, Голт бор 152, Тавилгана 1499, Улиас 150, Шинэс 120, Гацуур 34, нийт 2135 ширхэг мод ургаж амьдралтын хувь 43,6 байна.

Төв аймгийн 27 сумын хэмжээнд нийтийн цэвэрлэгээг 2019.09.09-ний өдөр зохион байгуулахад 160 аж ахуй нэгж, байгууллагын 2184 иргэд оролцон 477,8 тн хог хаягдлыг цэвэрлэн тээвэрлэх ажилд 2,1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Байгаль орчны багц хуулийн хүрээнд Эрдэнэ суманд амралт, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 37 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулав. Хяналт шалгалтаар 37 ААНБ-ын 00-ийн судалгааг гаргахад Нүхэн жорлон 8, боловсон 00-ийн 75, бохир цуглуулах цооног 28, багтаамжийн хэмжээ 510 тн гарсан. Мөн ус ашиглах дүгнэлт гаргуулаагүй 15, гэрээ байгуулж зөвшөөрөл аваагүй 19, усны тоолуур суурилуулаагүй 19 иргэн, ААН үйл ажиллагаа явуулж байна.

Илэрсэн зөрчлүүдийг арилгуулах талаар сум орон нутаг болон тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэл хүргүүлэн ажилласан.

Аймгийн Засаг даргын батласан удирдамжийн дагуу 2019 оны 09 дүгээр сарын 07-08-нд Идлэг шонхор шувуу барих зорилгоор буусан отгийн бичиг баримтийг шалган, “Байгаль орчныг хамгаалах тухай”, Амьтны тухай хууль, “Ус тухай ууль” Хог хаягдлын тухай хууль”, “Газрын тухай хууль” ЗГ-ын 2019 оны 293-р тогтоол болон БОАЖС-ын 299-р тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангуулах, зөвшөөрөлгүй галт зэвсэг авч яваа эсэх, сум орон нутагтай хэрхэн хамтарч ажиллах талаар мэдээлэл цуглуулах зорилгоор хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. 2019 оны 09 дүгээр сарын 07-ны байдлаар манай аймагт Катар, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират зэрэг 3 улсын нэр дээр 11 албан бичгээр 315 хүртэл тоо толгойг барих зөвшөөрөл олгосоны дагуу Сэргэлэн суманд 2, Баян суманд 3, Эрдэнэсант суманд 1, нийт 6 отог байрласан байна.

Орон нутгийн өмчийн чиглэлээр: Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, Монгол улсын ЗГ-ын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу 11 суманд ажиллаж мэргэжил арга зүйн удирлагаар хангасан.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: 2019 оны 9 сарын байдлаар Зуунмод, Батсүмбэр, Баян, Баян-Өнжүүл, Эрдэнэсант, Аргалант, Мөнгөнморьт, Эрдэнэ, Баяндэлгэр суманд ажиллан 216 бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулж Баталгаажуулалтын зөвлөлийн хурлыг 7, Баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлыг 8 удаа тус тус хуралдуулж, 176 үйлчилгээ, бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийг 1-2 жилийн хугацаагаар олгосон.

Тайлангийн хугацаанд 9 дүгээр сарын 17-ноос 21-ний өдрүүдэд Мөнгөнморьт, Баяндэлгэр, Эрдэнэ сумдад ээлжит баталгаажуулалтаар ажиллаж 33 худалдаа, нийтийн хоолны газрыг анхдагч болон давтан тохирлын үнэлгээнд хамруулав. Мөн Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт мөрдөх шинээр болон шинэчлэн батлагдсан MNS 4946:2019, MNS 5021-1:2019 стандартын талаар 30 гаруй ААНэгж, иргэнийг мэдээллээр хангалаа.

2019 оны 09 дүгээр сарын байдлаар тус хэлтсийн “Хэмжил зүйн нэгдсэн лаборатори” нь Зуунмод, Баян, Батсүмбэр, Эрдэнэсант, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Сэргэлэн, Эрдэнэ, Баянжаргалан, Баянчандмань, Архуст, Мөнгөнморьт, Заамар, Баяндэлгэр сумдын худалдаа, үйлчилгээний тооцоо, хүн, мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ оношлогоонд ашиглагдаж байгаа 4245 ш хэмжүүр, хэмжих хэрэгслийг баталгаажуулалтад хамруулсан.

Үндэсний болон байгууллагын стандартын санг бүрдүүлэн, тэдгээрээр иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байдал:

- ✓ 220 хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд стандартын мэдээлэл, лавлагаа өгч ажилласан.
- ✓ 15 иргэн, ААН-д 87 нэр төрлийн стандартыг олгосон.
- ✓ Батсүмбэр, Баян, Баянчандмань, Эрдэнэсант сумдын 71 худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын талаар мэдээлэл хийсэн.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

Аймгийн Эрүүл мэндийн салбарын гадаад харилцааг өргөжүүлэх хүрээнд БНСУ-ын Корё их сургуулийн Анам эмнэлэгтэй мэргэжлийн боловсон хүчнийг сургах, дадлагажуулах солилцооны хөтөлбөр, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх зэргээр хамтын ажиллагааг эхлүүлж, 5 жилийн хугацаатай хамтран ажиллах санамж бичгийг үзэглэлээ. Хамтын ажиллагааны эхлэл болгож Анам эмнэлгийн элэг, хавдар, бөөр, судасны нарийн

мэргэжлийн эмч нар аймгийн Нэгдсэн эмнэлгийн хяналтад байдаг элэгний В, С вирусийн халдвартай, элэгний хатууралтай 28 иргэн, бөөрний хүнд хэлбэрийн оноштой 18 иргэнд үзлэг оношлогоо хийсэн.

МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн санаачилсан “Хайртай” аяныг зохион байгуулав. Аяны хүрээнд "Эр хүний ноён нуруу", "Хөвгүүдийн уулзалт", "Хүүхэд хүмүүжүүлэх арга ухаан", "Эр хүний хийморь" цэнгүүн зэрэг 5 төрлийн уулзалтыг зохион байгуулахад нийт 7000 гаруй иргэд хамрагдсан.

Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан аймгийн “Хөдөлмөрч манлай ахмад”-ыг шалгаруулсан дүнг ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлснээр 7 сумын 9 ахмадыг шагнаж урамшууллаа.

Дэлгэрхаан суманд байрлах Дуутын хадны бичгийн 395 жилийн ойг тохиолдуулан 21 аймгийн яруу найрагч болон Болор цомын эзэн Баяржаргал, Л.Хасар, Ц.Эрдэнэбаатар, Гантулга, Баттулга нарыг оролцуулсан яруу найргийн уншлага арга хэмжээг тус дурсгалт газар зохион байгуулж, сумын соёлын төвийн шинэ барилгын нээлтэд оролцож, МТТ-ын уран бүтээлчдийн тоглолтыг иргэдэд толилууллаа.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр аймгийн хэмжээнд Хичээлийн шинэ жилийн нээлтийг зохион байгуулав. 2019-2020 оны хичээлийн жилд аймгийн ерөнхий боловсролын 31 сургуульд 15700 сурагч суралцах бөгөөд нэгдүгээр ангид 1600 сурагч элсэн орлоо.

Боловсролын салбарт үр бүтээлтэй ажилласан 13 багш, ажилтныг “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдгээр, 24 багш ажилтныг БСШУСЯ-ны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнуулахаар БСШУСЯ-нд уламжлаад байна.

Төв аймгийн соёл урлагийн салбарын өдрийг 29 байгууллагын 200 орчим албан хаагчдыг хамруулан тэмдэгллээ. Энэ арга хэмжээний хүрээнд “Соёл урлагийн байгууллагын тогтвортой хөгжил-удирдахуйн шинэлэг хандлага” сургалтыг зохион байгуулж, 20 гаруй ажилтан албан хаагчдыг шагнаж урамшуулав.

БСУГ-ын мэргэжилтнүүд нийт 33 багш, 510 суралцагч, 56 эцэг эх, сум орон нутгийн 5 удирдах ажилтныг хамруулан 2019 оны 9-р сарын 16-20 нд Баян, Баянжаргалан сумын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, баримт бичиг хөтлөлт, сургалтын үндсэн үйл ажиллагаатай танилцаж зөвлөн туслалаа.

2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ”-д БСУГ-аас нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, 4 төрлийн ажил үйлчилгээг иргэдэд хүргэсэн.

“Боловсролын салбарын өвөлжилтийн бэлтгэл хангалт болон хичээлийн жилийн бэлтгэл”, “Хичээл судлагдахуун бүрээр сургалтын чанарыг сайжруулах” аян, “Соёлын бодлого”-ын хэрэгжилт явцын талаарх асуудлуудыг Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Албан бус насан туршийн боловсролын төвийн үйлчилгээ: Баян, Баянжаргалан сумын насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, зөвлөн туслав.

Театрын үйлчилгээ: Тайлант хугацаанд 14 удаагийн арга хэмжээгээр нийт 2400 гаруй үзэгчдэд үйлчилсэн.

Халх голын ялалтын түүхт 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд МУ-ын баатар Б.Цог, Д.Самдан нарын хөшөөнд цэцэг өргөх ёслолын ажиллагаа болон баярын хурал, хүндэтгэлийн тоглолт зэргийг зохион байгуулж, нийт 450 гаруй үзэгчид үйлчилсэн.

Монгол туургатан театр, Нийтийн номын сан, Музейгээс хамтарсан “Соёл урлаг” сурталчлах өдөрлөгийг Баян, Баянжаргалан, Архуст, Баяндэлгэр сумдад зохион байгуулсан.

Музейн үйлчилгээ: Тайлант хугацаанд 1739 үзэгчид Музейн үйлчилгээг үзүүлж, 965.0 мян.төг-ийн орлого олж, өссөн дүнгээр нийт 7686.0 төгрөгийн орлогыг төвлөрүүлж 11227 үзэгчдэд үйлчиллээ. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Музейн хөгжил-

2019” чуулганд 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Сүмбэр, Сэргэлэн, Цээл сумын “Орон нутаг судлах танхим” хариуцсан ажилтнууд болон музейн ажиллагсад хамтран спортын арга хэмжээ, волейболын төрөлд оролцож, тавдугаар байр /тусгай байр/ эзэлсэн.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: 2019 оны 9-р сард 450 байнгын уншигч, 1432 ирэгсэд, нийт 1882 уншигчдад 3375 ном олгож уншууллаа.

Жил бүрийн 9-р сард улсын хэмжээнд зохион байгуулдаг “Үндэсний номын баяр”-ыг тохиолдуулан “Төв аймгийн залуус” ТББ, “Тархи цэнэглэгч” номын клуб санаачлан “Номын хур-2019” арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Аймгийн нийтийн номын сан хамтран оролцож Монгол Туургатан Театрт зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэж, 20%-ийн хямдралтай номын худалдаа, номын үзэсгэлэн гаргаж 148 иргэнд үйлчиллээ. “Уншлагыг дэмжих аян”-ы хүрээнд Нийгмийн салбарын байгууллагуудын дунд зохион явуулсан 1 сарын аяны дүн гарч Тэргүүн байрыг Гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн газар, Дэд байранд Боловсрол соёл, урлагын газар, Гутгаар байрыг аймгийн Музейн хамт олон шалгарсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, зорилгоор зохион байгуулсан “20 номын хожил” цэнгээнт нэвтрүүлэгт Төв аймгийн Засаг Даргын Тамгын Газар, Цагдаагийн газар, Төв Чандмань- Дулааны эрчим хүчний газар, УБЦТС ТӨХК-ийн Зуунмод хэрэглэгчдэд үйлчлэх төв, Төв аймгийн Нэгдсэн эмнэлэг гэсэн 5 байгууллага оролцлоо.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: Монголын хүүхдийн спортын VI их наадмын шигшээ тэмцээнд спортын 23 төрлөөр 262 тамирчин оролцож, 18 алт, 9 мөнгө, 24 хүрэл нийт 51 медаль хүртэж багийн дүнгээр улсын хэмжээнд 3-р байр, аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлаараа улсад 3-р байр эзэлсэн.

GOOD NEIGHBORS MONGOLIA – 2019 кросс гүйлтийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 09-р сарын 07-нд Зуунмод суманд зохион байгуулагдаж 19 байгууллагын 195 тамирчин оролцлоо.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: Атар газар эзэмшсний түүхт 60 жилийн ойг тохиолдуулан Монгол улсад анхны атрын шанг татсан залуусын хөдөлмөр бүтээлийг орчин цагийн залуу үед дурсан сануулах зорилготой “Атарчин залуусын арга хэмжээ”-г Жаргалант суманд энэ сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгууллаа. Илгээлтийн эздийг Атар, Намар, Тэмүүлэл, Нөхөрлөл, Октябрь, Залуучууд гэсэн 6 бригадад хуваан мэндчилгээ, төмс хураах уралдаан, буухиа тэмцээн, хоолны тэмцээнүүдээр өрсөлдүүлсэн юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан Монгол улсад нисэх хүчин үүсч хөгжсөний 95 жил, авто тээврийн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойг угтаж Зам тээврийн хөгжлийн яам, түүний харьяа Иргэний нисэхийн ерөнхий газраас зохион байгуулж буй “Хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалцгаая” уриатай адал явдалт авто экстрим аяллыг санаачлан 11 аймгийн нутаг дэвсгэрээр аялаж буй аялагч Д.Батзоригийг угтан авсан.

Охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах “Гүнж” төвтэй хамтран хэрэгжүүлж байгаа “Залуу эхчүүдийн манлайлал” хөтөлбөрийн хүрээнд Гүнж төв, Канадын Dufresne Gauthier сангийн төлөөлөгчид “Би нисдэг охин” монологийн бэлтгэлтэй танилцан, хөтөлбөрт хамрагдаж байгаа охид, нийгмийн ажилтнуудтай уулзаж ярилцлаа.

“Дэлхийн зөн Монгол” ОУБ-ын Төв орон нутгийн хөтөлбөртэй хамтран 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Зуунмод сумын ЕБС-ийн оролцооны байгууллагын 54 сурагчийг "Хүүхдийн аюулгүй, үр дүнтэй оролцоо" сэдэвт сургалтад хамрууллаа.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан "Ургацын талбайд-2019" арга хэмжээг 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Батсүмбэр сумын өрхийн тариаланч Х.Баасанхүүгийн тариалангийн талбайд зохион байгууллаа. Арга

хэмжээнд Хүмүүн цогцолбор ахлах сургуулийн Г.Ундрах багштай 116 ангийн 24 сурагч оролцож 1га талбайгаас 600 шуудай буюу 22 тонн төмс хураан авлаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/289 дугаар тушаалаар “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нээлттэй өдөрлөг”-ийг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд:

- ГБХЗХГ-ын үйл ажиллагааны мэдээлэл-87 иргэн
- Иргэдээс хүүхдийн хөгжлийн чиглэлийн дугуйлангийн үйл ажиллагааны цагийн хуваарь, төлбөр, хамрагдаж болох насны хязгаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх дэмжлэг тусламж-15 асуулт.
- Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой 2 иргэнд зөвлөгөө өгсөн
- ЗХТөв, Хүүхэд, залуучуудын чиглэлээр гарсан хууль тогтоомж үйл ажиллагааг сурталчлах-87 иргэн
- Иргэдээс 3 санал.
- Тараах материал, гарын авлага- 18 төрлийн 220 гарын авлага, тараах материалыг тарааж нийт 87 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

2019 оны 9-р сарын байдлаар /өссөн дүнгээр/ 1857 иргэнд 2719.3 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1192 иргэнд 756.1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1101 иргэнд 430.3 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 4050 ахмад настанд 370.8 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 422 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 92.6 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 1599 эхэд 273.2 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Алдарт эхийн одонтой 9052 эхэд 1213.4 сая төгрөг, алдар цолтой 59 ахмад настанд 83.87 сая төгрөг, 4975 ахмад настанд 420.1 сая төгрөгийн насны хишгийг олголоо. 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 5403 эхэд 2001.2 сая төгрөгийн тэтгэмж, 3 ба түүнээс дээш тооны 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон 284 эх /эцэг/-т 249.6 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

ХБХЭУЧОЛгох хөтөлбөрийн Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 77 иргэнийг хамруулж, Хөшигтийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын туслан гүйцэтгэх Савон Сонгдо компанид 15 иргэнийг ажилд зуучлан оруулсан. Мөн мэргэжил олгох сургалтанд Зуунмод, Сүмбэр, Борнуур, Бүрэн сумын 5 иргэн мэргэжил эзэмшихээр суралцаж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 59 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 30 ажил олгогч байгууллага, 121 сул чөлөөтэй ажлын байр, 74 ажилд зуучлагдсан иргэн, 70 шинэ ажлын байрыг мэдээллийн санд оруулав. Ажилгүйдлийн тэтгэмжид хамрагдах 17 иргэнд бүртгэлд хамрагдсан тодорхойлолтыг Нийгмийн Даатгалын Хэлтэст гаргаж өгсөн.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан малчдын дунд “Амжилтын түүх” чуулга уулзалтыг зохион байгуулахад 27 сумын 160 гаруй залуу малчид оролцов.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Баянчандмань сумын 205.000.000 төгрөгийн өр авлагаас 63.158.240 сая төгрөгийн өр авлагыг барагдуулж, 2 байгууллагын материалыг бүрдүүлэн авч шүүхээр шийдвэрлүүлэхээр, бусад байгууллагуудтай утсаар холбогдон ярилцаж график байгуулан төлөлт хийлгэхээр тохирсон.

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 4 удаа хуралдаж, нийт 236 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 25 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 191 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 2 иргэнийг цуцалсан байна.

2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр төрийн үйлчилгээний нэгдсэн төвд, 2019 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Мөнх-Алдарын талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг тус тус зохион байгуулж нийгмийн даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжид орсон өөрчлөлт ач холбогдлыг сурталчилсан. Мөн тэтгэвэрт гарах 54 иргэн даатгуулагч, эрүүл мэндийн даатгалд 76 иргэн, цахим үйлчилгээнд 48 иргэн, тэтгэмж, сайн дурын даатгалтай холбоотой 66 иргэн даатгуулагчдад мэдээлэл өгөв.

Аймгийн хэмжээнд архивын лавлагаа 646, тодорхойлолт 233, нөхөн даатгалын лавлагаа 48, аймаг, дүүрэг хоорондын лавлагаа 62, нийт 989 лавлагааг иргэд даатгуулагчдад өглөө.

248 иргэн, даатгуулагчдад 119.8 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон.

2019 онд хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Алтанбулаг, Баян-Өнжүүл, Сэргэлэн, Архуст, Баянжаргалан, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Эрдэнэ сумдад хяналт шалгалтаар 2017, 2018 оны шинээр тогтоосон нийт 586 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэрэг, тэтгэвэр тогтоолт, олголтыг шалгаж 36 ажил олгогчид 11,7 сая төгрөгийн улсын байцаагчдын акт тогтоосон.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Террорист халдлагаас сэргийлэх улсын команд штабын хээрийн дадлага сургуулалтыг Баянчандмань суманд зохион байгуулж, Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 09 сарын 04-ний А/47 тоот тушаалаар дадлага, сургуулалтад оролцох бие бүрэлдэхүүнийг томилон, 2019 оны 09 дүгээр сарын 11,12,13-ны өдрүүдэд ажиллав.

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Монголын эрүүл мэндийн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын хувийн хэвшлийн ЭМБ-ын Нэгдсэн холбооноос хамтран зохион байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн яармаг-2019”-г оролцож, хүний их эмч, уламжлалтын их эмч, эм зүйч, сувилагч, лаборант, рентген техникч зэрэг мэргэжлийн ажил хайж байгаа 200 орчим иргэдийг хүлээн авч уулзан, шаардлагатай байгаа сул ажлын байрны мэдээллийг хүргэсэн.

НҮБ-ын Хүн амын сангийн 10,2 сая төгрөгийн дэмжлэгтэйгээр АНЭ-ийн дэргэд байгуулагдсан “Өсвөр үеийн кабинет”-ийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Баян-Өнжүүл, Дэлгэрхаан сумын ЭМТ-д Засаг даргын нөөц сангаас 7,480,000 төгрөгийн үнэ бүхий вакцины хөргөгч болон 18 сумын ЭМТ-д 12 нэр төрлийн вакцин, дагалдах хэрэгслийг олгосон.

Борнуур сумын ЭМТ-д байгуулсан “Сүрьеэгийн лаборатори”-ийн нээлтийг 2019 оны 09 сарын 09-ны өдөр хийсэн.

Магадлан итгэмжлэгдсэн Өндөрширээт, Сэргэлэн сумын Эрүүл мэндийн төвүүд болон Замтын булаг, Мөнхжин сувиллуудын тусламж үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөрийн боловсруулалтад хяналт тавьж, баталгаажуулалт хийлгэхээр материалыг холбогдох газарт хүргүүлсэн.

Заамар, Алтанбулаг, Сүмбэр, Борнуур суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн ажилчид, хувиараа ашигт малтмал олборлогчид, хүн амын дунд сүрьеэ илрүүлэх үзлэг шинжилгээнд 1398 хүнийг хамруулсан. Рентген шинжилгээгээр сүрьеэгийн сэжигтэй 68, зөвхөн асуумжаар 22 оролцогчийг илрүүлснээс 110 хүний сорьцонд нян харах шинжилгээг хийсэн. Жене эксперт аппаратаар 3 эерэг сорьц илрүүлсэн.

Япон улсын Тоттори мужийн Төв эмнэлгийн хүүхдийн тасгийн эрхлэгч эмч Тамүра Акико, Тоттори мужийн Гадаад харилцааны хэлтсийн ажилтан Кояма Юкари, С.Цэрэндолгор гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй баг “Дутуу нярайд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах нь” сэдвээр дадлага сургалт зохион байгуулж, Нэгдсэн эмнэлгийн төрөх, хүүхдийн тасгийн эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд хамрагдсан.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлогын талаар: 2019 оны 09-р сарын байдлаар аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөө 10805,1 сая төгрөг оруулахаас 12101,6 сая төгрөг оруулж, 1296,5 сая төгрөг буюу 112,0 хувиар биелсэн. Сумдын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 128,1 хувь буюу 698,8 сая төгрөгөөр давж биелсэн байна. Сумдын төсвийн орлого давж биелэхэд үйл ажиллагааны орлого 146,0 сая төгрөг, хадгаламжийн хүүгийн орлого 104.9 сая төгрөг, ҮХЭХ борлуулсаны албан татвар 19,2 сая төгрөг, хүү торгуулийн орлого 51,2 сая төгрөг, бусад орлого 123,4 сая төгрөгөөр тус тус давсан нь нөлөөлжээ. Архуст, Баян, Баян-Өнжүүл, Баянцагаан, Мөнгөнморьт, Өндөрширээт, Зуунмод зэрэг 7 сумд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тасалдуулав.

Аймгийн төвлөрсөн төсвийн орлогоос ҮХЭХ-ийн орлого, ус ашигласны төлбөрийн орлого, хөрөнгө борлуулсны орлого, бусад нэр заагдаагүй орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Архуст, Баян, Баянжаргалан, Баяндэлгэр, Баянхангай, Дэлгэрхаан, Сэргэлэн, Сүмбэр, Угтаал, Эрдэнэ зэрэг 10 сум тасалсан байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар: Сумдад эхний 09 сарын өссөн дүнгээр нийт 52.141,7 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл:

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 20.907.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 14.273.2 сая төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 6.634.1 сая төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 5.669.4 сая төгрөгийг олгосон.Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 5.497.2 сая төгрөг

-Өрхийн эмнэлэгт 172.1 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 369.4 сая төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 291.7 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 24.903.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 14.900.9 сая төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 8.098.4 сая төгрөг

-ОНХСангуудад 1.904.4 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар: 2019 оны 9-р сарын ХБГүйцэтгэлээр сумд, болон төсөвт байгууллагууд нийт 116.8 сая төгрөгийн авлага, 436.0 сая төгрөгийн өглөгтэй байна. Нийт өглөгийн 89.8 сая төгрөг буюу 20,6 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 129.6 сая төгрөг буюу 29,9 хувь нь цалингийн өглөг, 92.1 сая төгрөг буюу 21,1 хувь нь НДШимтгэлийн өр, 11.540,5 мянган төгрөг буюу 2,6 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 44.244,7 мянган төгрөг буюу 10,1 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 68.756,8 мянган төгрөг буюу 15,7 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэлийг 94 зорилт 257 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан аймгийн ИТХ-д өргөн барив.

“Хөгжлийн түүчээ-Төв аймаг 2024” хэтийн зорилтын 2017-2019 оны хагас жилийн тайланг Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн ИТХ-д өргөн барихаар бэлтгэж байна.

ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд үүдний хэсгийн мэдээллийн самбарыг шинэчилж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэст удирдамжийн дагуу дотоод аудит хийж, дуугүй хөтөч байршуулсан.

ISO нэвтрүүлэх ажлын хүрээнд санаачилгатай ажилласан хэлтэс, алба, албан хаагчдыг урамшуулав.

“Монсертф” ХХК нь Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартын дагуу баталгаажуулалтын анхдагч аудит хийж байна.

Санхүүгийн хяналтын чиглэлээр: 2019 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцагаан, Борнуур, Батсүмбэр, Баянчандмань, Бүрэн, Эрдэнэсант, Өндөрширээт зэрэг 9 сум, Нийгмийн даатгал, Халамж, Эрүүл мэндийн даатгал, Сум хөгжүүлэх зэрэг 4 сан, Авто тээврийн газар, аймгийн ИТХ, Хот тохижуулах газар, Статистикийн хэлтэс зэрэг 4 байгууллага, иргэнээс ирсэн өргөдлийн дагуу 3 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 119554,0 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт, 2773109,4 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 5113.9 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна.

2019 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар 119554,0 мянган төгрөгний улсын байцаагчийн акт барагдуулахаас 31031,9 мянган төгрөгийн акт барагдаж, 26,0%-тай байна

Найм. Цэргийн штабын хүрээнд:

Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах өдөрлөгийг Халх голын дайны түүхт 80 жилийн ойн баяртай хамтатган тэмдэглэлээ. Батлан хамгаалах яам, ЗХЖШ, ҮБХИС, “Бөртэ” ТӨҮГ, “Алдар” спорт хороо, Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл, Монгол цэргийн музей, Батлан хамгаалахын төв архив, Цэргийн төв эмнэлэг, Барилга захиалагчийн алба, Зэвсэгт хүчний 016, 345 дугаар бригад, 011, 032, 084, 119 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн тус өдөрлөгт оролцов. Нээлтийн арга хэмжээнд УИХ, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Х.Батбилэг, ЗХЖШ-ын орлогч дарга, хошууч генерал Ж.Бадамбазар, Төв аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, төв аймгаас төрөн гарсан генералууд, ахмад дайчид, аймгийн иргэд оролцлоо. Батлан хамгаалахын төв архив, Цэргийн төв эмнэлэг иргэд, олон нийтэд үнэ төлбөргүй үзлэг хийж, мөн архивын лавлагаа олголоо.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/505 дугаар захирамж, Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2019 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр 97 багийн Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг Зэвсэгт хүчний 016 дугаар бригадын байрлалд зохион явууллаа. Сургалтыг нээлтийн арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын дарга Б.Цэрэндаваа, Цэргийн штабын дарга хошууч Т.Төмөрчөдөр, Цэргийн штабын офицерууд оролцлоо. Уг сургалтаар “Орон нутгийн хамгаалалтын тухай” хуулийн танилцуулга, “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Цэргийн тоо бүртгэл болон цэрэг татлага” –ын талаар хичээлүүд орсон бөгөөд ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн Г.Мөнхгэрэл, Статистикийн хэлтсийн дарга Ж.Отгончулуун, Тогтвортой амжиргаа-3 төслийн орон нутаг хариуцсан ажилтан Ц.Буманбуян нар мэдээлэл хийлээ.

Батлан хамгаалах сайдын н/01 дугаар тушаал, аймгийн Засаг даргын А/491 дүгээр захирамж, Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Дайчилгааны бэлтгэл нөөцийн 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 14 хоногийн хугацаатай Зэвсэгт хүчний 016 дугаар бригад дээр зохион явуулж байна. Уг сургалтаар химичин цэвэрлэгч, радио телеграфчин мэргэжлээр цэргийн бага мэргэжилтэн бэлтгэж байна.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар